



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СБА-2023/45/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баруун-Урт сум 2023 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Аудитор: О.Барчидгүнсэн Утас: 70512127</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	14
4.1 Ерөнхий зүйл .....	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	16
5.1 Төлбөрийг акт.....	16
5.2 Албан шаардлага.....	16
5.3 Зөвлөмж .....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	17

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН ТҮМЭНЦОГТ  
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА Г.ЭНХТУЯА ТАНАА

2023.03.22 № 150  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

### Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Засаг даргын Тамгын газар нь төрийн албан хаагчдын цалингийн нэгдсэн системд бүрэн нэвтэрч, төрийн сангийн ажил гүйлгээг цахим болох бэлтгэл ажлын ханган ажиллаж байна.

### Бусад асуудлын хэсэг

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Засаг даргын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 15 зорилтын хүрээнд 64 арга хэмжээг төлөвлөн, гүйцэтгэл 58.5 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>92,811,788.00</b>	<b>132,466,555.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	2,820,000.00	4,645,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,820,000.00	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	4,645,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	4,645,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	89,991,788.00	105,483,555.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	3,402,520.00	3,402,520.00
35110	Тусгай зориулалттай материал	3,402,520.00	3,402,520.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	320,000.00	200,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	67,469,268.00	82,571,035.00
35410	Бичиг хэргийн материал	795,408.00	650,128.00
35420	Аж ахуйн материал	80,000.00	381,900.00
35470	Бусад хангамжийн материал	66,593,860.00	81,539,007.00
35600	Мал амьтад	18,800,000.00	19,310,000.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	-	22,338,000.00
36300	Тэжээлийн нөөц	-	22,338,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,005,608,008.10</b>	<b>1,619,228,027.27</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,005,608,008.10	1,619,228,027.27
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	991,280,008.10	1,603,137,777.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	608,578,520.10	756,928,090.23
39202	Хуримтлагдсан элэгдэл	(99,663,601.36)	(127,726,221.25)
39203	Авто-тээврийн хэргэсэл	222,440,550.00	204,474,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(190,410,216.79)	(51,123,800.19)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	176,238,769.00	150,804,640.02
39206	Хуримтлагдсан элэгдэл	(81,619,049.87)	(46,342,120.20)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,669,344.00	38,647,944.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(30,650,476.63)	(30,033,776.39)
39214	Бусад үндсэн хөрөнгө	936,286,125.00	994,276,486.48
39215	Хуримтлагдсан элэгдэл	(590,589,955.35)	(286,768,265.43)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	14,328,000.00	16,090,250.00
39301	Програм хангамж	-	1,995,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(232,750.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	14,328,000.00	14,328,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,098,419,796.10</b>	<b>1,751,694,582.27</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,321,857.00</b>	<b>15,583,000.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	3,321,857.00	15,583,000.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	3,321,857.00	15,583,000.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	3,321,857.00	15,583,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	5,845,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	3,321,857.00	9,738,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,095,097,939.10</b>	<b>1,736,111,582.27</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,095,097,939.10	1,736,111,582.27
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	483,719,481.17	483,719,481.17
51101	Өмч: - төрийн	483,719,481.17	483,719,481.17

<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	306,381,050.63	947,394,693.80
51210	Өмнөх үеийн үр дүн	306,381,050.63	306,381,050.63
51220	Тайлант үеийн үр дүн	-	641,013,643.17
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	304,997,407.30	304,997,407.30
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,098,419,796.10</b>	<b>1,751,694,582.27</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>586,464,253.00</b>	<b>1,382,675,042.63</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>732,432,577.63</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	732,432,577.63
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	732,432,577.63
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	732,432,577.63
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>586,464,253.00</b>	<b>650,242,465.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	6,135,953.00	49,952,365.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	50,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	42,448,165.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,100,953.00	3,704,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	985,000.00	3,800,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	580,328,300.00	600,290,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	580,328,300.00	600,290,100.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>641,664,535.96</b>	<b>741,661,399.46</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>641,664,535.96</b>	<b>741,661,399.46</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	586,931,655.60	717,769,930.19
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	247,142,943.00	294,750,036.00
210101	Үндсэн цалин	149,367,930.00	186,893,079.00
210102	Нэмэгдэл	48,756,199.00	60,558,147.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,461,000.00	19,488,000.00
210104	Урамшуулал	8,900,166.00	13,574,273.00
210105	Гэрээт ажлын хөлс	26,657,648.00	14,236,537.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	32,102,504.00	37,504,280.78
210201	Тэтгэврийн даатгал	22,471,934.48	25,725,330.49
210202	Тэтгэмжийн даатгал	2,450,687.81	2,817,619.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,824,452.84	2,390,176.12
210204	Ажилгүйдлийн даатгал	610,205.67	595,713.54
210205	Эрүүл мэндийн даатгал	4,745,223.20	5,975,441.58
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	30,863,742.64	22,689,188.54
210301	Гэрэл, цахилгаан	10,806,342.64	2,631,788.54
210302	Түлш, халаалт	19,542,600.00	19,542,600.00
210303	Цэвэр, бохир ус	514,800.00	514,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	15,634,585.00	20,620,568.50
210401	Бичиг хэрэг	3,480,200.00	3,477,900.00
210402	Тээвэр, шатахуун	8,895,020.00	13,683,118.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,259,365.00	2,610,390.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	849,160.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	450,000.00	-
210502	Хоол, хүнс	50,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	400,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	14,711,000.00	6,268,200.00
210604	Урсгал засвар	14,711,000.00	6,268,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,330,000.00	6,333,000.00
210702	Дотоод албан томилолт	2,330,000.00	6,333,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	24,391,259.00	63,150,251.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,648,500.00	62,577,926.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	180,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	371,700.00	392,325.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	239,059.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	219,305,621.96	266,454,405.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	101,487,701.00	151,399,996.91
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,611,000.00	1,555,850.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	115,206,920.96	113,498,558.46
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	54,732,880.36	23,891,469.27
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	14,467,642.00	11,985,230.16
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	5,953,400.00	5,946,830.16
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,013,242.00	3,638,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,501,000.00	2,400,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	5,852,473.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,852,473.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	40,265,238.36	6,053,766.11
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,265,238.36	6,053,766.11
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(55,200,282.96)</b>	<b>641,013,643.17</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(55,200,282.96)</b>	<b>641,013,643.17</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>595,336,861.00</b>	<b>653,062,465.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>595,336,861.00</b>	<b>653,062,465.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	15,008,561.00	52,772,365.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	50,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,872,608.00	42,448,165.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,100,953.00	6,524,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	985,000.00	3,800,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	580,328,300.00	600,290,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	580,328,300.00	600,290,100.00

<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>546,774,601.00</b>	<b>588,779,773.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>546,774,601.00</b>	<b>588,779,773.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>489,221,720.64</b>	<b>564,888,303.73</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	244,021,288.00	297,702,456.00
210101	Үндсэн цалин	146,246,275.00	188,231,448.00
210102	Нэмэгдэл	48,756,199.00	60,558,147.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,461,000.00	19,488,000.00
210104	Урамшуулал	8,900,166.00	13,574,273.00
210105	Гэрээт ажлын хөлс	26,657,648.00	15,850,588.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	31,733,067.00	37,873,717.78
210201	Тэтгэврийн даатгал	22,102,497.48	26,094,767.49
210202	Тэтгэмжийн даатгал	2,450,687.81	2,817,619.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,824,452.84	2,390,176.12
210204	Ажилгүйдлийн даатгал	610,205.67	595,713.54
210205	Эрүүл мэндийн даатгал	4,745,223.20	5,975,441.58
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	30,863,742.64	22,689,188.54
210301	Гэрэл, цахилгаан	10,806,342.64	2,631,788.54
210302	Түлш, халаалт	19,542,600.00	19,542,600.00
210303	Цэвэр, бохир ус	514,800.00	514,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	15,634,585.00	20,670,568.50
210401	Бичиг хэрэг	3,480,200.00	3,477,900.00
210402	Тээвэр, шатахуун	8,895,020.00	13,683,118.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,259,365.00	2,610,390.00
210404	Ном, хэвлэл	-	50,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	849,160.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	450,000.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	50,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	400,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	18,436,050.00	6,268,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	75,050.00	-
210604	Урсгал засвар	18,361,000.00	6,268,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,440,000.00	3,395,000.00
210702	Дотоод албан томилолт	3,440,000.00	3,395,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	17,448,759.00	4,055,029.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,706,000.00	3,482,704.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	180,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	371,700.00	392,325.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	239,059.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	127,194,229.00	172,234,143.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	124,583,229.00	170,678,293.91
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,611,000.00	1,555,850.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>57,552,880.36</b>	<b>23,891,469.27</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	14,467,642.00	11,985,230.16
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	5,953,400.00	5,946,830.16
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,013,242.00	3,638,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,501,000.00	2,400,000.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	5,852,473.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,852,473.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	43,085,238.36	6,053,766.11
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,265,238.36	6,053,766.11
213404	Хөрөнгийн	2,820,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	48,562,260.00	64,282,692.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	26,520,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	26,520,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	26,520,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	26,520,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(26,520,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	48,562,260.00	37,762,692.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	483,719,481.17	304,997,407.30	274,131,850.16	-	1,062,848,738.63
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	483,719,481.17	304,997,407.30	274,131,850.16	-	1,062,848,738.63
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	32,249,200.47	-	32,249,200.47
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	483,719,481.17	304,997,407.30	306,381,050.63	-	1,095,097,939.10
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	483,719,481.17	304,997,407.30	306,381,050.63	-	1,095,097,939.10
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	483,719,481.17	304,997,407.30	306,381,050.63	-	1,095,097,939.10
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	641,013,643.17	-	641,013,643.17
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	483,719,481.17	304,997,407.30	947,394,693.80	-	1,736,111,582.27

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	879813800.00	567716333.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	879813800.00	567716333.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	834430400.00	555731103.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	282993500.00	297527456.00
210101	Үндсэн цалин	178574600.00	188231448.00
210102	Нэмэгдэл	59292300.00	60558147.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17540000.00	19488000.00
210104	Урамшуулал	14886600.00	13399273.00
210105	Гэрээт ажлын хөлс	12700000.00	15850588.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36406100.00	37873717.78
210201	Тэтгэврийн даатгал	25086300.00	26094767.49
210202	Тэтгэмжийн даатгал	2830100.00	2817619.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	2263900.00	2390176.12
210204	Ажилгүйдлийн даатгал	566200.00	595713.54
210205	Эрүүл мэндийн даатгал	5659600.00	5975441.58

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	31440100.00	22689188.54
210301	Гэрэл, цахилгаан	5400000.00	2631788.54
210302	Түлш, халаалт	25340100.00	19542600.00
210303	Цэвэр, бохир ус	700000.00	514800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	32000000.00	19571368.50
210401	Бичиг хэрэг	5000000.00	3307900.00
210402	Тээвэр, шатахуун	18200000.00	12793918.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,600,000.00	2,570,390.00
210404	Ном, хэвлэл	1,200,000.00	50,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	849,160.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,959,700.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,959,700.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	73,700,000.00	6,268,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,000,000.00	-
210602	Тавилга	3,400,000.00	-
210604	Урсгал засвар	50,300,000.00	6,268,200.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	6,300,000.00	3,395,000.00
210702	Дотоод албан томилолт	6,300,000.00	3,395,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,541,000.00	1,091,029.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	610,000.00	518,704.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	225,000.00	180,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	765,000.00	392,325.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	350,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,391,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	365,090,000.00	167,315,143.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	360,890,000.00	165,759,293.91
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,200,000.00	1,555,850.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	45,383,400.00	11,985,230.16
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	45,383,400.00	11,985,230.16
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	5,953,400.00	5,946,830.16
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,638,400.00	3,638,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27,791,600.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,000,000.00	2,400,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	606,343,866.11
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	606,343,866.11
132001	Орон нутгийн төсвөөс	-	606,343,866.11

## 2.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>9,157,200.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>9,157,200.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	9,157,200.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	175,000.00
210104	Урамшуулал	175,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,099,200.00
210401	Бичиг хэрэг	170,000.00

210402	Тээвэр, шатахуун	889,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	40,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,964,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,964,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,919,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,919,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>52,772,365.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>52,772,365.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,448,165.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,524,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,800,000.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Засаг даргын Тамгын газар нь “Сум орон нутгийн хөгжил дэвшлийг хангаж нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, төрийн бодлого шийдвэр, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг иргэн бүрд ил тод, жигд хүртээмжтэй хүргэх” эрхэм зорилгын хүрээнд сумын нийгэм эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн оновчтой бодлого, нийгмийн салбарын хөгжлийг ахиулахад дэмжлэг үзүүлэх зорилго, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 626,700,7 мянган төгрөгөөр буюу 57 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	
Авлага	2,820.0	4,656.0	1,825.0
Бараа материал	89,991.7	97,953.5	7,961.7
Үндсэн хөрөнгө	1,005,608.0	1,619,078.0	613,470.0
Нийт хөрөнгө	<b>1,098,419.7</b>	<b>1,725,120.5</b>	<b>626,700.7</b>
Өр төлбөр	3,321.8	15,583.0	12,261.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,095,097.9	1,709,537.5	614,439.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<b>1,0984,19.7</b>	<b>1,725,120.5</b>	<b>626,700.7</b>

- Авлагын данс 4,656.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны авлагыг барагдуулсан бөгөөд хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төслийн авлага байна.
- Үндсэн хөрөнгө данс 1,619,078.0 мянган төгрөг болж 613,470.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь сумын ОНХС-ийн хөрөнгөөр залуучууд хөгжлийн төв, цамхагт гэрэлтүүлэг, хогийн машин, ариутгалын машин гэх мэт 586,950.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 26,520.0 мянган төгрөгөөр хөрөнгө нэмэгдэж, элэгдлийн зардлаар буурсан байна.
- Засгийн газрын хувь оролцоо данс 614,439.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 612,014.1 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс орон төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 879,813.8 мянган төгрөг батлагдсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээнд орон нутгийн төсвөөс 879,813.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 594,236.3 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 594,236.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 6,053.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 285,577.8 мянган төгрөг буюу 69.8 хувьтай зарцуулсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	80801- Үндсэн үйл ажиллагааны зардал	461,913.2	370,648.9	91,264.40	80.2
2	80106-Баг, хорооны үйл ажиллагааны зардал	56,467.2	53,822.7	2,644.50	95.3
3	80714-Ахмад наснуудад үзүүлэх хөнгөлөлт	5,953.4	5,946.8	6.60	99.9
4	80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, дэмжлэг	39,430	6,038.4	33,391.60	15.3
5	81102-Орон нутгийн нөөц сан	60,000.0	42,737.3	17,262.80	71.2
6	81518-Мөрийн хөтөлбөрт тусгасан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх	214,690.0	92,116.7	122,573.40	42.9
7	81549-Ахмад сан	1,360.0	1,360.0	0.00	100.0
8	81701-Байгаль хамгаалах, нөхөн сэргээх	40,000.0	21,565.5	18,434.50	53.9
<b>НИЙТ</b>		<b>879,813.8</b>	<b>594,236.3</b>	<b>285,577.8</b>	<b>69.8</b>

Орон нутгийн төсвийн орлого тасарсантай холбоотой засаг даргын нөөц сан, мөрийн хөтөлбөрт тусгасан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх зардлууд дутуу санхүүжигдсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 42,448.1 мянга, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 6,524.2 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого 3,800.0 мянга нийт 52,772.3 мянган төгрөгийн орлого төвлөрч гүйцэтгэлээр 46,919.8 мянган төгрөгийг зарцуулж 5,852.5 мянган төгрөгийг дээд шатны төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалтыг авч үзвэл тээвэр шатахууны зардалд 889.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 40,726.7 мянга, бусад зардалд 5,303.9 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

---

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Барчидгүнсэн, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС-2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 578,102.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,671.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1<sup>1</sup>, 15.2.3<sup>2</sup>-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд 8,174.5 мянган төгрөгөөр буурсан, тээвэр шатахууны зардал 4,788.1 мянга, албан томилолтын зардал 4,003.0 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Дээрх зардал өмнөх оноос нэмэгдсэн учир шалтгааныг авч үзвэл:

- *Тээвэр шатахуун, бичиг хэргийн зардал: Шатах тослох материал, бичиг хэргийн материалын үнэ өмнөх оноос дунжаар 52.0 хувиар нэмэгдсэн нь гол нөлөөлөл үзүүлсэн байна.*

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

---

<sup>1</sup> байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

<sup>2</sup> сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гаргасан тушаал шийдвэр, орлого зарлагын мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Засаг даргын Тамгын газарт завсрын аудитаар үндсэн хөрөнгийн тулгалт тооллогын комисс эд хөрөнгө нэг бүрийг үзэж, үнэн зөв бодитой тооллого хийгээгүй, тооллогын дүнг нягтлан бодогчтой тулгаж баталгаажуулаагүй зөрчил илэрсэн. Мөн ажилчин, албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл хөтлөөгүй байсан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1<sup>3</sup>, 72.4.2<sup>4</sup>, 72.4.4<sup>5</sup>, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6<sup>6</sup> дахь заалттай нийцэхгүйд зөвлөмж өгсөн.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	333.1	1	333.1	100
Албан шаардлага	3	33,319.8	3	33,319.8	100
Зөвлөмж	1	-	1	-	
Нийт дүн	5	33,652.9	5	33,652.9	100

<sup>3</sup> эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах;

<sup>4</sup> тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн үнийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих;

<sup>5</sup> комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;

<sup>6</sup> эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 47,066.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 4,000.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 43,062.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, нэг зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийг акт

5.1.1 Урлагийн наадмыг зохион байгуулахад найруулагч хөлсөөр гэрээ байгуулан ажиллуулж, гэрээний үлдэгдэл 4,000.0 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл дутуу, нэгдүгээр гарын үсэг зураагүй баримтаар шилжүүлжээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5<sup>7</sup>, 13.6<sup>8</sup>, 13.7<sup>9</sup> Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1<sup>10</sup>, 41 дүгээр зүйлийн 41.2.3<sup>11</sup> заалттай тус тус нийцэхгүй байна.

### 5.2 Албан шаардлага

5.2.1 Бараа үйлчилгээний бусад зардлаас худалдан авсан 32,135.0 мянган төгрөгийн ажлын гэрээг дүгнээгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6<sup>12</sup>, 13.7<sup>13</sup> дахь заалттай нийцэхгүй байна.

5.2.2 Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг байршуулаагүй. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8<sup>14</sup> заасныг зөрчсөнд албан шаардлага өгөв.

5.2.3 Хөдөө аж ахуйн тасагт байвал зохих 1 орон тоог бүтцэд батлаагүйгээс ажлын байрны тодорхойлолт заагдсан чиг үүрэг орхигдож, тухайн ажлыг гүйцэтгэх зорилгоор 2 албан хаагчид 40 хувийн нэмэгдэл олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.9<sup>15</sup>, 41 дүгээр зүйлийн 41.2.3<sup>16</sup>, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2<sup>17</sup>, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2<sup>18</sup>, Засгийн газрын 2019 оны 267 дугаар тогтоолтой тус тус нийцэхгүй байна.

5.2.4 Төсвийг зохистой удирдан өр авлага үүсгэхгүй байх зарчмын хүрээнд үйл ажиллагааг зохион байгуулалгүй 10,927.0 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1<sup>19</sup>, 6.4.8<sup>20</sup>, 41 дүгээр зүйлийн 41.2.2<sup>21</sup>, 41.2.4<sup>22</sup>, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5<sup>23</sup> Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар 20.2.5<sup>24</sup> заалттай нийцэхгүй байна.

<sup>7</sup> Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна

<sup>8</sup> Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна

<sup>9</sup> Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно

<sup>10</sup> төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

<sup>11</sup> төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах

<sup>12</sup> Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна

<sup>13</sup> Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно

<sup>14</sup> бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр,

авлага үүсгэсэн аливаа шийдвэр

<sup>15</sup> дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах,

бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох

<sup>16</sup> төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах

<sup>17</sup> Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ

<sup>18</sup> Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газраас нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтоох бөгөөд аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газар нь хэлтэс, тасагтай байна/

<sup>19</sup> төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

<sup>20</sup> төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх

<sup>21</sup> батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах

<sup>22</sup> төсвийн сар, улирлын хуваарийг баримталж ажиллах

<sup>23</sup> хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх

<sup>24</sup> дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### ***Цахим худалдан авах холбоотой асуудал***

##### ***5.3.1 Илрүүлэлт:***

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ." заасны дагуу хүсэлтийг холбогдох байгууллагад хүргүүлээгүй байна.

##### ***Өгсөн зөвлөмж:***

Тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээ цахим дэлгүүрт байхгүй тохиолдолд холбогдох бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэх, цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахгүй "Tender.gov.mn"-аас бараа бүтээгдэхүүнийг худалдан авч ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл												
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Үүнээс Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
гэрээ байгуулан ажиллуулж, гэрээний үлдэгдлийг анхан шатны баримтын бүрдэл дутуу, нэгдүгээр гарын үсэг зураагүй баримтаар шилжүүлжээ.	1	4,000.0	1	4,000.0								
Хөдөө аж ахуйн тасагт байвал зохих 1 орон тоог бүтцэд батлаагүйгээс ажлын байрны тодорхойлолт заагдсан чиг үүрэг орхигдож, тухайн ажлыг гүйцэтгэх зорилгоор 2 албан хаагчид 40 хувийн нэмэгдэл олгосон байна.	1				1							
Өр авлага үүсгэхгүй байх зарчмын хүрээнд үйл ажиллагааг зохион байгуулалгүй 10,927.0 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн.	1	10,927.0			1	10,927.0						
Бараа үйлчилгээний бусад зардлаас худалдан авсан 32,135.0 мянган төгрөгийн ажлын гэрээг дүгнээгүй, анхан шатны	1	32,135			1	32,135.0						

баримтын бүрдэл дутуу байна.													
Дүн	4	47,062.0	1	4000.0	3	43,062.0							

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал									
/мянган төгрөгөөр/									
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>									
www.shilendans.gov.mn цахим хуудсанд хугацаа хоцроож мэдээллэсэн	1	0			1	0			
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>0</b>			<b>1</b>	<b>0</b>			